Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: ЭСРЭГ ҮЗЭГДЛҮҮДИЙН МАГАДЛАЛ VII-22.1-I

Эсрэг үзэгдлүүд	Нэгдэл нь бүх боломжит үзэгдлийн олонлог болох хоёр үзэгдэл $P(A)+P(\overline{A})=1$	Үзэгдэл	Эсрэг үзэгдэл
		Шоо орхиход “6” нүдээр буух	Шоо орхиход 1-ээс 5 хүртэлх тоонуудын аль нэгээр нь буух
		Бороо орох	Бороо орохгүй байх
		Нэг оронтой тоо сонгоход 3-т хуваагддаг тоо байх	Нэг оронтой тоо сонгоход 3-т хуваагддаггүй тоо байх

1. Үзэгдэл бүрийн эсрэг үзэгдлийг бич.

а. Уутанд байгаа 4 өнгийн бөмбөгнөөс 1 бөмбөг сонгов.

$A=$ “улаан бөмбөг байх” бол $\overline{A}=$ *Улаан биш байх*

б. Гар утасны дугаар сонгов.

$A=$ “Сүүлийн орон 0 эсвэл 1 байх” бол $\overline{A}=$ *0 эсвэл 1-ээр төгсөөгүй байх*

в. Санамсаргүй нэг сурагч сонгов.

$A=$ “Өвлийн улиралд төрсөн байх” бол $\overline{A}=$ *Өвлөөс бусад улиралд төрсөн байх*

2. Эсрэг үзэгдлийг нь нэрлээд магадлалыг нь олоорой.

а. Хөлбөмбөгийн тоглолтод А баг хожих магадлал 0.61

$\overline{A}=$ *А баг хожихгүй байх*, $P(\overline{A})=$ 0.39

б. Сугалаанд хонжвор таарах магадлал 20%

$\overline{A}=$ *Хонжвор таарахгүй байх*, $P(\overline{A})=$ 80%

3. Үзэгдэл болон түүний эсрэг үзэгдлийн магадлалыг ол.

а. 6 талт шоо орхив. P(3-т хуваагддаг тоогоор буух)= $\frac{1}{3}$

$P($*3-т хуваагддаггүй тоо байх*$)=\frac{2}{3}$

в. 5 улаан, 6 цэнхэр, 2 ягаан бөмбөгнөөс 1 бөмбөг авав. P(улаан байх)= $\frac{5}{13}$

$P($*Улаан биш байх*$)=\frac{8}{13}$

г. 5000 барааны 15 нь гологдол байв. Санамсаргүй 1 бараа сонгов

P(гологдол байх)= 0.003

$P($*Гологдол биш байх*$)=$ 0.997

д. Уралдаанд 6-р ангийн 6, 7-р ангийн 7, 8-р ангийн 8 сурагч оролцож нэг нь түрүүлэв.

P(8-р ангийн сурагч түрүүлэх)= $\frac{8}{21}$

$P($*8-р ангийн сурагч түрүүлээгүй байх*$)=\frac{13}{21}$

4. Гар утсан дээр 4 өдрийн цаг агаарын урьдчилсан мэдээ гарчээ. Өгүүлбэрүүдийг бага боломжтойгоос нь их рүү нь жагсаагаарай.

А. Баасан гарагт бороо орохгүй.
Б. Бямба гарагт бороо орохгүй.
В. Даваа гарагт бороотой.
Г. Ням гарагт бороо орно.

Б, Г, В, А

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: ЭСРЭГ ҮЗЭГДЛҮҮДИЙН МАГАДЛАЛ VII-22.1-II

Үзэгдэл	Эсрэг үзэгдэл
Нэг оронтой тоо сонгоход 3-аас их тоо байх	Нэг оронтой тоо сонгоход 3-аас ихгүй тоо байх
3 оронтой тоо сонгоход “3” цифр оролцоогүй байх	3 оронтой тоо сонгоход ядаж нэг цифр нь 3 байх

1. Үзэгдэл бүрийн эсрэг үзэгдлийг бич.

а. 2 оронтой нэг тоо сонгов.

A = “Хамгийн багадаа 20 байх” бол $\overline{A}$ = *20-оос их тоо байх*

б. 2 оронтой нэг тоо сонгов.

A = “3 ба 4-ийн ядаж нэгд нь хуваагддаг байх” бол $\overline{A}$ = *3 ба 4-ийн алинд ч хуваагддаггүй байх*

в. Гар утасны дугаар сонгов.

A = “Нэг ширхэг “3” цифр оролцсон байх” бол

$\overline{A}$ = “ *3 цифр оролцоогүй байх* болон *1-ээс олон 3 цифр оролцсон байх* ”

г. 7 номны 3 нь математикийн ном байв. Санамсаргүйгээр 3 ном сонгов.

A = “Ядаж нэг нь математикийн ном байх” бол $\overline{A}$ = *Математикийн ном сонгоогүй байх*

2. Улаан, цэнхэр, ягаан бөмбөгнүүдтэй уутнаас санамсаргүй нэг бөмбөг авахад улаан болон ягаан байх магадлал харгалзан 0.4 ба 0.25 байв. Санамсаргүй авсан бөмбөг цэнхэр өнгөтэй байх магадлалыг ол.

0.35

3. Тоон олонлогоос санамсаргүй нэг тоо сонгоход 10-аас бага тоо таарах магадлал 0.25, 100-аас их тоо таарах магадлал 0.56 байв.

P(10-аас багагүй, 100-аас ихгүй тоо таарах) =

0.19

4. 100-аас ихгүй хэдэн тоог нэг нэг цаасан дээр бичиж уутанд хийв. Санамсаргүй нэг тоо сонгоход 50-аас ихгүй тоо таарах магадлал 0.55, 90-ээс багагүй тоо таарах магадлал 0.1 байв.

P(50-аас их, 90-ээс бага тоо таарах) =

0.35

5. 100 сугалааны 1 нь хонжвортой байв. Туяа 3 сугалаа авчээ.

P(Хонжвор таарахгүй байх) = 0.97

P(Хонжвор таарах) = 0.03

6. 2 шоог зэрэг орхив.

P(Туссан нүднүүд ижил байх) = $\frac{1}{6}$

P(Туссан нүднүүд ялгаатай байх) = $\frac{5}{6}$

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: ЭСРЭГ ҮЗЭГДЛҮҮДИЙН МАГАДЛАЛ VII-22.1-III

Үзэгдэл	Эсрэг үзэгдэл
4 оронтой тоо сонгоход ядаж 2 цифр нь ижил байх	4 оронтой тоо сонгоход бүх цифр нь өөр байх
Санамсаргүй 4 хүүхэд сонгоход хамгийн цөөндөө хоёр нь охин байх	Санамсаргүй 4 хүүхэд сонгоход хамгийн цөөндөө гурав нь хүү байх

1. Ангийн сурагчдаас 3 сурагч сонгожээ. Үзэгдэл бүрийг эсрэг үзэгдэлтэй нь холбо.

Ядаж нэг нь хүү байх	Ядаж хоёр нь охин байх
Гурвуул хүү байх	Гурвуул охин байх
Ядаж хоёр нь хүү байх	Ядаж нэг нь охин байх

2. Хоёр зоосыг зэрэг орхив.

A = "Ядаж нэг нь сүлдээр буух"

$\overline{A}$ = *Хоёул тоогоор буух* $P(A) = \frac{3}{4}$

3. Сурагч асуулт бүр нь тийм, үгүй гэсэн хоёр сонголттой, 4 асуулттай шалгалт өгчээ.

A = Ядаж хоёр асуултад зөв хариулсан байх үзэгдлийн эсрэг үзэгдлийг бич.

$\overline{A}$ = *Ядаж 3-т буруу хариулах*

4. Улаан болон цагаан бөмбөгнүүдийг дараалан байрлуулав. Цагаан бөмбөгнүүд зэрэгцэн байрлаагүй байх үзэгдлийн магадлал $\frac{5}{14}$ бол ядаж хоёр цагаан бөмбөг зэрэгцэн байрласан байх үзэгдлийн магадлалыг ол.

A = "Цагаан бөмбөгнүүд зэрэгцэн байрлаагүй байх"

$\overline{A}$ = *Ядаж 2 цагаан зэрэгцсэн* $P(A) = \frac{9}{14}$

5. Тамирчин байг дараалан хоёр удаа онох магадлал 0.64 байв.
Дараалан хоёр удаа буудахад ядаж нэгд нь алдах магадлалыг ол.

Ω = { *Оносон - О, Алдсан - А гэвэл ОО, ОА, АО, АА* }

$P(A)$ = 0.36

6. Ах дүү хоёр "Хайч, чулуу, даавуу" тоглоом тоглох болов. Ах нь "Миний ялах магадлал $\frac{1}{3}$" гэхэд дүү нь "Тэгвэл миний ялах магадлал $\frac{2}{3}$ байх нь ээ" гэжээ. Хэн нь зөв хэлсэн бэ?

"Дүү ялах" үзэгдэл нь "Ах ялах" үзэгдлийн эсрэг үзэгдэл биш.

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: ЭСРЭГ ҮЗЭГДЛҮҮДИЙН МАГАДЛАЛ VII-22.2-I

Үзэгдлийн магадлалыг ол. Эсрэг үзэгдлийг нь нэрлээд магадлалыг нь ол.

1. Гэр бүлийн гишүүд болох аав, ээж, 2 охин, 1 хүү ээлжлэн оройн хоолны дараа аяга тавгаа угаадаг. Өнөөдрийн оройн хоолны дараа аяга, тавгаа угаах

A = "Эмэгтэй хүн угаах" $P(A)=$ 0.6

$\overline{A}=$ *Эрэгтэй хүн угаах* $P(\overline{A})=$ 0.4

B = "Хүүхэд угаах" $P(B)=$ 0.6

$\overline{B}=$ *Том хүн угаах* $P(\overline{B})=$ 0.4

2. 8 улаан, 6 цэнхэр, 5 ягаан, 2 хар бөмбөгнөөс 1 бөмбөг авав.
A = "Цэнхэр эсвэл ягаан байх"

$P(A)=\frac{11}{21}$

$\overline{A}=$ *Улаан эсвэл хар байх*

$P(\overline{A})=\frac{10}{21}$

3. 3 оронтой 1 тоо санамсаргүй сонгов.
A = "3-т хуваагддаг тоо байх"

$P(A)=\frac{1}{3}$

$\overline{A}=$ *3-т хуваагддаггүй тоо байх*

$P(\overline{A})=\frac{2}{3}$

4. 2 шоог зэрэг орхив. A = "Туссан нүднүүдийн нийлбэр 2 эсвэл 12 биш байх"

$\overline{A}=$ *Нийлбэр 2 эсвэл 12 байх*

$P(\overline{A})=\frac{1}{18}$

$P(A)=\frac{17}{18}$

5. Гологдол гаргах магадлал нь харгалзан 0.1, 0.05, 0.06 байх 3 өөр үйлдвэрээс тэнцүү тооны ижил бараа ирэв. Санамсаргүй 1 бүтээгдэхүүн сонгов.
P(Гологдол биш бүтээгдэхүүн таарах)=

0.93

6. Гар утасны дугаарын сүүлийн 4 оронг сонгов.
A = "3 болон 5 цифр оролцсон байх",

$\overline{A}=$ *3 болон 5 цифр оролцоогүй байх*

$P(\overline{A})=\frac{256}{625}$

$P(A)=\frac{369}{625}$

7. 5 сурагч нэг эгнээнд зогсов.
A = "Болд яг голд нь зогсоогүй байх"

$\overline{A}=$ *Голд нь зогссон байх*

$P(\overline{A})=$ 0.2

$P(A)=0.8$

Дасгалын дугаар																				Нийт
Өөрийн үнэлгээ																				
Багшийн үнэлгээ																				

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: ЭСРЭГ ҮЗЭГДЛҮҮДИЙН МАГАДЛАЛ VII-22.2-II

1. Хар ба цагаан өнгийн хоёр шоог зэрэг орхив.

A = "Туссан нүднүүдийн үржвэр тэгш тоо байх"

$\overline{A}$ = *Туссан нүднүүдийн үржвэр сондгой тоо байх*

$P(\overline{A})$ = 0.25

$P(A)$ = 0.75

B = "Туссан нүднүүдийн нийлбэр 3-аас их байх"

$\overline{B}$ = *Нийлбэр 2 байх* болон *Нийлбэр 3 байх*

$P(\overline{B})$ = $\frac{1}{12}$

$P(B)$ = $\frac{11}{12}$

2. 6 оронтой тоо сонгов.

A = "Сүүлийн хоёр цифрийн ядаж нэг нь тэгш байх",

$\overline{A}$ = *Сүүлийн 2 орон сондгой байх*

$P(\overline{A})$ = 0.25

$P(A)$ = 0.75

3. 5 оронтой тоо сонгов.

A ="Сүүлийн хоёр цифр нь дараалсан тоонууд биш байх"

$\overline{A}$ = *Дараалсан тоонууд байх*

$P(\overline{A})$ = 0.09

$P(A)$ = 0.91

4. 5 сурагч нэг эгнээнд зогсов.

A = "Болд, Бат хоёр зэрэгцэн зогсоогүй байх"

$\overline{A}$ = *Зэрэгцэн зогссон байх*

$P(\overline{A})$ = 0.4

$P(A)$ = 0.6

5. Уутанд 1-ээс 10 хүртэлх дугаартай 10 бөмбөг байв. Санамсаргүй 2 бөмбөг авав.

A = "Дугааруудын нийлбэр нь 5-д хуваагддаггүй байх"

$\overline{A}$ = *5-д хуваагддаг байх*

$P(\overline{A})$ = $\frac{7}{45}$

$P(A)$ = $\frac{38}{45}$

6. Уутанд 3 улаан, 8 цэнхэр, 5 ягаан бөмбөг байв. Санамсаргүй 2 бөмбөг авав.

A = "Ядаж нэг нь цэнхэр бөмбөг байх"

$\overline{A}$ = *Цэнхэр бөмбөг ороогүй байх*

$P(\overline{A})$ = $\frac{7}{30}$

$P(A)$ = $\frac{23}{30}$

7. Болдоо асуулт бүрд "Тийм", "Үгүй" гэж хариулдаг. Болдоос 5 асуулт асуув.

A = "Ядаж 2-т "Тийм" гэж хариулсан байх"

$\overline{A}$ = *Бүгд үгүй эсвэл 1 тийм*

$P(\overline{A})$ = $\frac{3}{16}$

$P(A)$ = $\frac{13}{16}$

Дасгалын дугаар																				Нийт
Өөрийн үнэлгээ																				
Багшийн үнэлгээ																				

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: ЭСРЭГ ҮЗЭГДЛҮҮДИЙН МАГАДЛАЛ VII-22.2-III

1. Уутанд 4 хөх, 3 улаан, 2 ногоон бөмбөг байв. Санамсаргүй 3 бөмбөг авчээ.

A = "Ядаж хоёр нь ижил өнгөтэй бөмбөг байх"

$\overline{A}$ = *Бүгд өөр өнгөтэй байх*

$P(\overline{A}) = \frac{2}{7}$ $P(A) = \frac{5}{7}$

2. Уутанд 4 цагаан, 3 улаан, 2 ногоон бөмбөг байв. Санамсаргүй 3 бөмбөг авчээ.

A = "Ядаж хоёр нь өөр өнгөтэй байх"

$\overline{A}$ = *Бүгд ижил өнгөтэй байх*

$P(\overline{A}) = \frac{5}{84}$ $P(A) = \frac{79}{84}$

3. Цагаан толгойн 35 үсэгнээс 2-ыг сонгов.

A = "Ядаж нэг нь гийгүүлэгч байх"

$\overline{A}$ = *Бүгд эгшиг эсвэл тэмдэг үсэг байх*

$P(\overline{A}) = \frac{3}{17}$ $P(A) = \frac{14}{17}$

4. Сурагч 10 асуултын 2-ыг нь огт бэлдээгүй байв. Шалгалт авахдаа эдгээр 10 асуултаас 3-ыг нь санамсаргүй сонгож авдаг.

A = "Ядаж нэг бэлдээгүй асуулт орсон байх"

$\overline{A}$ = *Бүгд бэлдсэн асуулт байх*

$P(\overline{A}) = \frac{7}{15}$ $P(A) = \frac{8}{15}$

5. Зоосыг 5 удаа орхив. .

A = "Ядаж хоёр удаа сүлдээр буусан байх "

$\overline{A}$ = *Бүгд тоо байх* болон *1 нь сүлд 4 нь тоо буух*

$P(\overline{A}) = \frac{3}{16}$ $P(A) = \frac{13}{16}$

6. 4 хүү, 4 охиноос 5 хүүхэд сонгох болов.

A = "Хоёроос цөөнгүй хүү сонгогдсон байх"

$\overline{A}$ = *Нэг нь хүү байх*

$P(\overline{A}) = \frac{1}{14}$ $P(A) = \frac{13}{14}$

Дасгалын дугаар																				Нийт
Өөрийн үнэлгээ																				
Багшийн үнэлгээ																				

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: ХАРЬЦАНГУЙ ДАВТАМЖ БА МАГАДЛАЛ VII-22.3-II

$$\text{Харьцангуй давтамж} = \frac{\text{Туршилтад илэрсэн тоо}}{\text{Туршилтын тоо}}$$

1. Харьцангуй давтамжийн хүснэгтийг нөхөж гүйцээ.

Жин	40	50	60	45	30
Сурагчийн тоо	10	12	5	13	10
Харьцангуй давтамж	0.2	0.24	0.1	0.26	0.2

2. Ууттай бөмбөгнөөс нэг бөмбөг аваад өнгийг тэмдэглэн буцааж хийх туршилт хийжээ. Туршилтын үр дүнг давтамжийн хүснэгтээр харуулав.

Өнгө	Улаан	Цэнхэр	Ногоон	Шар
Давтамж	𝍸 |||	𝍸 𝍸 |	𝍸 |||	||||

Энэ уутнаас санамсаргүй нэг бөмбөг авахад тэр нь ногоон байх магадлал (харьцангуй давтамж)-ыг ол.

$$\frac{4}{15}$$

3. Зурагт өгсөн хүрдийг эргүүлэх туршилт хийж, зүү зогссон өнгүүдийг хүснэгтэд бүртгэжээ.

Өнгө	Улаан	Цэнхэр	Ногоон	Шар
Давтамж	5	9	3	3

Өнгө бүр дээр зогссон харьцангуй давтамжийг ол.

Аль өнгө таарах магадлал нь онолын магадлалтайгаа тэнцүү байна вэ?

4. Шоог 300 удаа орхиж нүд бүр хэдэн удаа туссаныг диаграммд харуулав.



Харьцангуй давтамжийг магадлалтай нь харьцуул.

Сондгой тоогоор туссан тоо = 147, $\text{Х.Д} = \frac{147}{300} < 0.5$

4-өөс их тоогоор туссан тоо = 97

5.

Зурагт өгсөн хүрдийг эргүүлж, зүү нь тоо бүр дээр хэдэн удаа зогссоныг харуулав.

а. 4-өөс багагүй тоон дээр зогсох

б. 3-аас ихгүй тоон дээр зогсох

харьцангуй давтамж ба магадлалыг харьцуул.

Туршилтын тоо 200

а. 0.385 < 0.4 б. 0.615 > 0.6

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

СЭДЭВ: ХАРЬЦАНГУЙ ДАВТАМЖ БА МАГАДЛАЛ VII-22.3-III

1. Хүрд эргүүлэхэд зүү тусах боломж нь өгсөн нөхцлийг хангадаг байхаар хувааж буд.



Улаан ба ногоон нь нийлээд 50% боломжтой, ногоон нь хамгийн бага боломжтой, шар нь ногооноос их, цэнхэр нь шараас их боломжтой.



Бүх өнгө 50%-аас бага боломжтой. Улаан ба шар нь 25% боломжтой, улаан нь хамгийн бага боломжтой, ногоон нь улаанаас их, цэнхэр нь шараас их боломжтой.

2. Сагсан бөмбөгийн тамирчин 20 удаа цагаригт довтлоход оруулахад 9-ийг нь алджээ. Тамирчин 50 удаа довтлоход ойролцоогоор хэдэд нь бөмбөгөө оруулах вэ?

28

3.

Өнгө	Давтамж
Цэнхэр	3
Ногоон	12
Улаан	9
Шар	6

Уутанд 4 өнгийн 50 ширхэг даам байв.
Харалгүйгээр нэгийг сугалах туршилт хийж өнгө бүрээс гарч ирсэн тоог бүртгэжээ.
Өнгө бүрээс ойролцоогоор хэд байсан бэ?

Нийт туршилтын тоо _____30_____

Х.Д(Цэнхэр) = 0.1

Х.Д(Ногоон) = 0.4

Х.Д(Улаан) = 0.3

Х.Д(Шар) = 0.2

Цэнхэр бөмбөгийн тоо _____5_____

Ногоон бөмбөгийн тоо _____20____

Улаан бөмбөгийн тоо _____15_____

Шар бөмбөгийн тоо _____10_____

4. 18 тэнцүү хэсэгт хуваагдсан хүрд эргүүлж тоглоом хожих магадлал $\frac{1}{6}$ байв.

а. Хүрдний хэдэн хэсэг нь хожилтой вэ? 3

б. Хүрдийг 540 удаа эргүүлбэл ойролцоогоор хэдэн ширхэг тоглоом хожих вэ? 90

5. Хоёр өөр зоосыг зэрэг орхих туршилт хийж, үр дүнг хүснэгтэд бүртгэв.

Туссан үр дүн	ТТ	ТС	СТ	СС
Давтамж	23	26	29	22

а. Хэдэн удаагийн туршилт хийсэн бэ?

100

б. Эгэл үзэгдэл бүрийн харьцангуй давтамжийг магадлалтай нь харьцуул.

$0.23<0.25$, $0.26>0.25$, $0.29>0.25$, $0.22>0.25$

в. Ядаж нэг удаа сүлдээр буух үзэгдлийн харьцангуй давтамжийг магадлалтай нь харьцуул.

$0.77 > 0.75$

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг

Сурагчийн овог нэр: _____ Эхэлсэн ... он ... сар ... өдөр ... цаг

ТЕСТ 22. ҮЗЭГДЛИЙН МАГАДЛАЛ VII-22

1. “Уралдаанд түрүүлэх” үзэгдлийн эсрэг үзэгдэл аль вэ?

А. Хоёрдугаар байранд орох
Б. Сүүлийн байранд орох
В. Түрүүлэхгүй байх
Г. Хоёр эсвэл гуравдугаар байранд орох

2. $P(A) = 0.35$ бол $P(\overline{A})$ аль нь вэ?

А. 0.53 Б. 0.55 В. 0.65 Г. 1.35

3. Талсууд дээр нь 1-ээс 12 хүртэлх тоог бичсэн зурагт үзүүлсэн биетийг шидэхэд аль нэг талс нь дээш харж тусдаг. Нэг удаа шидэхэд 3-д хуваагддаг тоогоор тусаагүй байх үзэгдлийн магадлал аль вэ?

А. $\frac{1}{3}$ Б. $\frac{2}{3}$ В. $\frac{5}{6}$ Г. $\frac{1}{6}$

4. 1, 2, 3, 4, 5 тоонуудаас санамсаргүйгээр нэгийг сонгох туршилт 30 удаа хийжээ. Хэрэв 1, 2, 3, 4 тоонууд харгалзан 7, 5, 7, 6 удаа бичигдсэн бол 5 тоо бичигдэх үзэгдлийн харьцангуй давтамжийг ол.

А. $\frac{2}{15}$ Б. $\frac{1}{6}$ В. $\frac{1}{5}$ Г. $\frac{1}{10}$

5. Дээрх туршилтын 2 тоо бичигдэх үзэгдлийн харьцангуй давтамж нь магадлалаасаа ямар зөрөөтэй байна вэ?

А. $\frac{1}{15}$-ээр их Б. $\frac{1}{15}$-ээр бага В. $\frac{1}{30}$-ээр их Г. $\frac{1}{30}$-ээр бага

6. 6 охин, 5 хүүгээс хоёр хүүхэд сонгов. Сонгосон 2 хүүхэд хоёул охин байх үзэгдлийн эсрэг үзэгдэл аль вэ?

А. Хоёул хүү байх
Б. Хүү ба охин байх
В. Яг нэг нь хүү байх
Г. Ядаж нэг нь хүү байх

7. Хоёр шатарчин хоёр удаа тоглов. Ядаж нэг удаад нь тэнцэх магадлал 0.46, хоёулаа нэг нэг хожих магадлал 0.27 бол хоёр тоглолт хоёулаа нэг шатарчны ялалтаар өндөрлөх магадлалыг ол. Боломжит 9 эгэл үзэгдлийг бичээд дэлгэрэнгүй бодолт хийнэ үү.

0.27

Дасгалын дугаар																			Нийт
Өөрийн үнэлгээ																			
Багшийн үнэлгээ																			

Дууссан ... он ... сар ... өдөр ... цаг